

"ЛэндМН ББСБ" ХК




lendmn



2026

| I улирлын санхүү,
үйл ажиллагааны тайлан

Flexibusiness



БИЗНЕСИЙН
ӨСӨЛТИЙГ ТАНЬ
ДЭМЖИНЭ



Агуулга

"ЛэндМН ББСБ" ХК-ийн 2026 оны I улирлын
санхүү, үйл ажиллагааны тайлан

Бизнесийн үйл ажиллагаа

01

Санхүүгийн үзүүлэлтүүд

02


Компанийн засаглал

03

БИЗНЕСИЙН ЗЭЭЛИЙН ҮР НӨЛӨӨ

“ЛэндМН ББСБ” ХК (цаашид “ЛэндМН”) нь 2024 оноос эхлэн Бичил, жижиг дунд бизнес эрхлэгчдийнхээ үйл ажиллагааг дэмжих зорилгоор FLEXI BUSINESS бүтээгдэхүүнийг зах зээлд нэвтрүүлсэн билээ. Бид энэхүү бүтээгдэхүүнээрээ дамжуулан мянга мянган бизнес эрхлэгчдийн бизнесийг дэмжин ажилласаар байгаа бөгөөд 2026 оны I улирлын байдлаар бизнесийн зээлийн нийт багцад эзлэх хувь 43.3 хувьд хүрч, 2025 оны I улиралтай харьцуулахад 17.3 нэгж хувиар өссөн үзүүлэлттэй байна. Энэхүү бизнесийн бүтээгдэхүүн нь анх танилцуулагдсан цагаасаа хойш тогтмол өсөлттэй байгаа нь бичил, жижиг дунд бизнесүүдэд санхүүжилтийн эрэлт их байгааг харуулж байна.

Бизнесийн зээлийн нийт зээлийн багцад эзлэх хувь хэмжээ



ЛэндМН-н үндсэн зорилгуудын нэг бол Монгол Улсад санхүүгийн тэгш хүртээмжийг нэмэгдүүлэх бөгөөд бид барьцаагүй, уян хатан санхүүжилтийн шийдлүүдийг зах зээлд нэвтрүүлж, уламжлалт санхүүгийн үйлчилгээний хүртээмж багатай сегментүүдэд хүрэхийг зорин ажиллаж байна. Олон улсын жишгийн адил Монгол Улсад ч эмэгтэйчүүд, орлого багатай иргэд, хөдөө орон нутгийн болон залуу бизнес эрхлэгчид банк санхүүгийн байгууллагуудын санхүүжилтэд хамрагдах боломж харьцангуй хязгаарлагдмал хэвээр байна. Иймд бид эдгээр бүлгүүдэд чиглэсэн санхүүжилтийг тэлэхэд онцгой анхааран ажиллаж байна.

2026 оны I улиралд зөвхөн бизнесийн зээлийн хүрээнд:

- Хөдөө орон нутгийн харилцагчдын тоо 4.9 нэгж хувиар,
- Эмэгтэй харилцагчдын тоо 7.8 нэгж хувиар,
- Бичил бизнес эрхэлдэг харилцагчдын тоо 15.7 нэгж хувиар,
- 35-аас доош насны залуу бизнес эрхлэгчдийн тоо өмнөх оноос 2 дахин өссөн байна.

2025 оны I улирал болон 2026 оны I улирлын харьцуулалт



Flexi Business зээлийн харилцагчдын 92% нь санхүүжилт авснаас хойш борлуулалт нь өссөн, 36% нь шинэ ажлын байр бий болгож, бичил, жижиг, дунд бизнесүүдийн өсөлт, орлогын тогтворжилтод дэмжлэг үзүүлж, улсын эдийн засгийн хөгжилд бодитой хувь нэмэр оруулсаар байна.





Бид зээл олгохоос гадна харилцагчдын бизнесийн өсөлт, борлуулалтыг дэмжих зорилгоор 2025 оны 4 дүгээр сард зах зээлд амжилттай нэвтрүүлсэн LendDy (Хүссэнээ аваад, Хүслээрээ төл) бүтээгдэхүүн маань 2026 оны I улирлын байдлаар буюу 1 (нэг) жилийн хугацаанд 7,000 гаруй мерчант буюу хамтран ажиллагчидтай болоод байна. Эдгээр хамтран ажиллагчдын 25% нь хөдөө орон нутагт бизнес эрхлэгчид байгаа нь бидний мерчантын хүрээ газарзүйн байршлаас үл хамааран тэлж буйн илрэл юм. Түүнчлэн манай нийт мерчантуудын 44%-ийг эмэгтэй бизнес эрхлэгчид, 37%-ийг залуу мерчантууд буюу 35-аас доош насны бизнес эрхлэгчид эзэлж байгаа нь ЛэндМН-ийн санал болгож буй уян хатан санхүүжилтийн шийдлүүд бичил, жижиг дунд бизнесүүдийн өсөлтийг дэмжихэд бодитой хувь нэмэр болж байна.



САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Санхүүгийн үзүүлэлтүүд өмнөх онуудын мөн үетэй харьцуулсан байдлаар



Орлого, үр дүнгийн нэгтгэсэн тайлан

/тэрбум төгрөг/	2024 I	2025 I	2026 I
Нийт орлого	17.9	28.8	39.3
Хүүгийн зардал	(3.9)	(7.7)	(12.4)
Цэвэр орлого	14.0	21.1	26.9
Зээлийн үйл ажиллагаатай холбоотой зардал	(2.4)	(5.4)	(11.0)
Үйл ажиллагааны цэвэр орлого	11.6	15.7	15.9
Удирдлагын болон ҮА-ны зардал	(2.1)	(3.4)	(3.7)
Татварын өмнөх ашиг	9.5	12.3	12.2
Татварын зардал	(2.3)	(2.5)	(2.3)
Цэвэр ашиг	7.2	9.8	9.9

Санхүү байдлын нэгтгэсэн тайлан

Хөрөнгө /тэрбум төгрөг/	2024 I	2025 I	2026 I
Мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгө	9.6	11.5	64.0
Зээлийн багц (цэвэр)	154.1	250.4	313.4
Бусад хөрөнгө	0.6	2.8	15.3
Үндсэн хөрөнгө	1.3	4.8	4.1
Биет бус хөрөнгө	0.3	0.7	1.3
Нийт хөрөнгө	165.9	270.2	398.1

Өр төлбөр болон эздийн өмч

Өр төлбөр	116	187.4	286.3
Эх үүсвэр	90	169.1	254.1
Хоёрдогч өглөг	2.8	2.8	13.6
Бусад өглөг	23.2	15.5	18.6
Эздийн өмчийн дүн	49.9	82.8	111.8
Хувьцаат капитал	8.5	8.5	8.5
Хуримтлагдсан ашиг	41.4	74.3	103.3
Нийт өр төлбөр болон эздийн өмч	165.9	270.2	398.1



ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРАЛ

“ЛэндМН ББСБ” ХК нь Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаа 9 дэх жилдээ амжилттай зохион байгууллаа. “ЛэндМН ББСБ” ХК нь 2025 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаа 2026 оны 03 дугаар сарын 28-ны өдөр Галлериа Улаанбаатар төвийн 3 давхарт зохион байгуулсан ба Хуралд нийт саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн 81.65% буюу 603,672,804 ширхэг хувьцааг эзэмшиж буй хувьцаа эзэмшигчид оролцоноор тус хурал хүчин төгөлдөр болсон бөгөөд дараах асуудлуудыг хэлэлцэж баталсан юм. Үүнд:

- ✓ Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн аудитлагдсан тайлан;
- ✓ Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлт;
- ✓ ТУЗ-ийн 2025 оны үйл ажиллагааны тайлан;
- ✓ Компанийн ТУЗ-ийн гишүүдийг сонгох;
- ✓ ТУЗ-ийн 2026 оны төсөв;



НОГДОЛ АШИГ

“ЛэндМН ББСБ” ХК (MSE:LEND) нь нээлттэй компани болсон цагаасаа эхлэн 12,000 гаруй хувьцаа эзэмшигчдийнхээ эрх ашгийг хамгаалж, тогтмол ногдол ашиг хүртээх, мөн нээлттэй, ил тод байхад үргэлж анхаарч ирсэн билээ. Түүнчлэн, бид хувьцаа эзэмшигчдийнхээ санал бодлыг чөлөөтэй хүлээн авч, үйл ажиллагаандаа тусган, цаашдын зорилтдоо хэрэгжүүлэн ажиллахыг эрмэлздэг. “ЛэндМН ББСБ” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн ээлжит хурлаас 2025 оны жилийн эцсийн цэвэр ашгаас Компанийн хувьцаа эзэмшигчдэд олгох ногдол ашгийн нэгж хувьцаанд ногдох хэмжээг 16.5 (арван зургаа аравны тав) төгрөгөөр тогтоож, 2025 оны цэвэр ашгийн 30.4 (гуч аравны дөрөв) хувийг буюу нийт 12,198,477,769.5 (арван хоёр тэрбум нэг зуун ерэн найман сая дөрвөн зуун далан долоон мянга долоон зуун жаран ес аравны тав) төгрөгийн ногдол ашгийг хувьцаа эзэмшигчдэдээ мөнгөн хэлбэрээр хуваарилахаар шийдвэрлэсэн юм.

Тус ногдол ашгийг Төлөөлөн удирдах зөвлөлийн зүгээс ногдол ашиг авах эрхтэй компанийн хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн 2026 оны 02 дугаар сарын 27-ны өдөр байхаар тогтоосны дагуу нийт 12,896 (давхардаагүй тоогоор) 2026 оны 04 дүгээр сарын 03-ны өдөр “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК-аар дамжуулан хувьцаа эзэмшигчдийн дансанд олгоод байна.

“ЛэндМН ББСБ” ХК-ийн технологиор дамжуулан бүгдэд нээлттэй, урт хугацааны үнэ цэнэтэй ирээдүйг хамтдаа бүтээх зорилгыг үргэлж дэмжиж, итгэл хүлээлгэсэн эрхэм хувьцаа эзэмшигчид, итгэлт түншүүд, үнэнч харилцагч та бүхэндээ чин сэтгэлийн талархал илэрхийлье.





ВЕБСАЙТ: **УТАС:** **ИМЭЙЛ:**
www.lend.mn 7707-0101 board@lend.mn